

Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Барааны тодорхойлолт: Цооног өрөмдөх, цооногийг тоноглох

- Геофизикийн судалгаа хийж, худгийн байршлыг эцэслэн тогтооно.
- Өрөмдмөл худгийн цооногийн ашиглалтын ударга нэг цэгт 2м^3 -ээс 6м^3 ус өгөх хүчин чадалтай байна.
- Суултын болон шүүрийн яндангийн материал нь ган буюу зөвшөөрөгдсөн хуванцар яндан байна.
- Ус өргөх ган буюу зөвшөөрөгдсөн хуванцар яндангийн диаметр 32мм байна.
- Цооног дахь суултын яндан, шүүр 20-оос доошгүй жил ашиглах нөхцөлийг хангасан байвал зохино.
- Ус шүүх хайрга нь шигшсэн, мөлгөр хэлбэртэй, тоосонцор хольцгүй, мөхлөгийн хамжээ 10-15мм байна.
- Худгийн шавхалт хийх хугацаа 24 цаг байна.
- Худгийн уснаас дээж авч шинжилгээ хийлгэсэн байна.
- Худгийн түр хугацааны тагаар тоноглох шаардлагатай.

Худгийн насос, цахилгааны утас, хянах самбар

- Цахилгааны утас нь худагт ашиглах шаардлагыг хангасан 3 фазын, насосноос хянах самбар хүртэл үргэлжилсэн /залгаасгүй/, ус өргөх янданд 2м тутамд хавчиж тогтооно.
- Хянах самбар нь асаах, унтраах товчлууртай байна. Насос ажиллагаагүй байх үед ногоон гэрэл, хүчдэл өгч ажиллаж байх үед улаан гэрэл асаж байхаар тохируулна.

Худгийн ажлыг дуусгаж хүлээлгэж өгөх

- Талбайг цэвэрлэнэ. /өрөмдлөгийн шлам, талбай зассан цементний баглаа боодол, хайрга чулуу болон ахуйн хог хаягдал гэх мэт.../
- Худаг, гүний насос, жижиг оврын генераторыг ажиллуулах, үйлчилгээ хийх талбайн сургалтыг худаг ашиглагч нарт хийнэ.
- Худгийн паспортыг бэлтгэж баталгаажуулан сумын ЗДТГ-ын хөдөө аж ахуйн тасагт хүлээлгэж өгнө.

2. Стандарт: Гүний насос: ISO9001 стандартын шаардлага хангасан. Монгол орны уур

амьсгалын нөхцөлд ашиглах боломжтой байна. Гарал үүслийн гэрчилгээтэй, үйлдвэрлэгчийн нэр, хаяг, барааны олон улсын гэрчилгээтэй байна.

Монгол улсын Хөдөө Аж Ахуйн сайд, Байгаль орчны сайд, Сангийн сайдын 2005 оны 7 дугаар сарын 15-ний өдрийн 101, 189, 194 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан “Инженерийн хийцтэй худаг, уст цэгийг сэргээн засварлах, шинээр гаргах, санхүүжүүлэх, эзэмших, ашиглах нийтлэг журам”-ыг мөрдөнө.

Бараа хүргэх газар: Нийт 3 худаг гаргана.